

Хүн ам зүйн хөгжлийн удирдлагыг боловсронгуй болгох арга зам

П. Гансүх

Удирдахуйн ухааны доктор,
БСШУЯ-ны газрын дарга

XX зуунд дэлхий дахиныг хамарсан нийгмийн болон хүн ам зүйн хувьсгалын аль алины хүрээнд татагдан орсон хийгээд ардчилал, зах зээлийн эдийн засгийг эргэлт буцалтгүйгээр сонгосон Монгол улсын түүхнээ нэгэн зуун төдийгүй нэгэн мянган солигдож байна. Монгол улс дэлхийн хамтын нийгэмлэгтэй хамт XXI зуунд шилжин орлоо. Энэхүү шилжилтийн ирээдүйг өөдрөгөөр төсөөлөх нь зүйн хэрэг ч, мундахгүй олон шалгалт, сорилтуудтай тулгарах нь мэдээж юм.

Монголын хүн ам зүйн хөгжлийн удирдлага нь дотроо **ерөнхий ба тусгай** хэмээн хоёр хуваагдахаар байна. Хүн ам зүйн хөгжлийн ерөнхий удирдлага нь улс орны хөгжлийн суурь үзэл баримтлалтай холбоотой, нийтлэг эрх ашгаар нөхцөлдөх учиртай ахул тусгай удирдлага нь Монгол улсын хүн ам зүйн хөгжлийн үйл явцаар л тодорхойлогдоно. Хүн ам зүйн хөгжлийн ерөнхий ба тусгай бодлого нь үйлчлэх хүрээ, механизм, нөлөөллийнхөө хэр зэргэмжээр харилцан адилгүй ч, бие биенийгээ тэтгэн дэмжсэн, нөхөн сэлбэсэн шинжтэйг зориуд онцолмоор байна.

XXI зууны Монгол орны хөгжлийн үндсэн үзэл баримтлал, удирдлагын чиг үүрэг нь "тогтвортой хөгжил", "хүний капитал буюу хүн төвтэй нийгэм" гэсэн хоёр янзын, тэгэхдээ агуулга, мөн чанар, багтаамжаараа давхардал, зохицол бүхий томъёоллын хүрээнд тодорч байна. Монгол улсын "тогтвортой хөгжил"-д хандах хандлага ч бас онцлогтой бололтой. Тухайлбал: Монгол орны тогтвортой хөгжлийг судлаачдын нэг хэсэг нь хүрээлэн буй орчинтой, байгаль эхтэй хамтад нь, нөгөө хэсэг нь Зүүн хойд Азийн бүс нутгийн хөгжилтэй шүтэлцүүлэн дэлхийн түвшнээр баримжаалж байна. Гэтэл зарим нь Монгол орны хөгжлийн дотоод эх сурвалж, язгуур шинжийг иш үндэс болгон бүсчлэн хөгжүүлэх, хэвтээ, босоо, тэнхлэгтэй тэр битгий хэл Монгол орныг дайран өнгөрч болзошгүй ОХУ-аас Япон хүртэлх хийн хоолойгоор багцаалах явдал ч байна. Энэ бүгд дор бүрнээ үндэслэлтэй, бас эсэргүүцэл, сөрөг нотолгоо, учирлалтай бөлгөө.

Тогтвортой хөгжлийн хүрээнд хүн ам зүйн хөгжлийн удирдлагыг боловсронгуй болгох хувилбар, арга замууд бий. Гэхдээ Монголын хүн ам зүйн хөгжил нь өөрөө тогтвортой байдлыг гэхээсээ тогтворгүй, тодорхойгүй байдлын эх сурвалж, хүчин зүйл болж буйг тооцож үзэх шаардлагатай.

XXI зуунд ч одоогийн хүн амын залуужилт үргэлжилнэ, тэгэхдээ нэг ажиллагчид ногдох "хүн ам зүйн ачаалал" зэрэг чиглэлээр өөрчлөгдөнө. Энэ бол маш чухал хандлага билээ. Гэвч манай улсын эдийн засгийн хүчин чадал, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын идэвхжил нь шинээр хөдөлмөрийн насанд дэвшин ирэгчдэд хүрэлцэхүйц ажлын байрыг зэхэж чадахгүй. Хүн ам зүйн "ажилгүйдэл" байсаар, нийгмийн хурц асуудал хэвээр байх болно. Эмх замбараагүй төлөв байдлыг бий болгодог ажилгүйдэл, ядуурал ихтэй тийм нийгэм нь удирдлагаар бус, урсгалаараа хөгжих нь илүүтэй. Нийгмийн болон хүн ам зүйн урсгал, эмх замбараагүй төлөв байдал нь аяндаа цэгцрэлийг олж, системлэг бөгөөд удирдлагат шинжийг олдог хэмээн орчин үеийн сенергетикийн шинжлэх ухаан нотолж байна. Үүний сацуу нийгмийн үзэгдлүүд нь нэг бус, олон хувилбар бүхий хөгжилтэй байдаг нь асуудлыг улам бүр төвөгтэй болгож байгаа билээ.

Монгол улсын хүн ам зүйн хөгжлийг хүний нөөц, хүний хүчин зүйл, хүний капиталын орчилд удирдах боломж бас бий. Тогтвортой хөгжлийн тухай саяхнаас ирмүүхэн ярих болсон, харин хүчин зүйлийн тухай бол аль социализмын үед ярилцаж байсан, зарим нэг онолын судалгаа ч, практик алхмууд ч хийгдсэн.

Хүний хүчин зүйлийн далбаан дор хүн ам зүйд хандах хандлага өөрчлөгдөж, хүн ам зүйн бодлого, үзэл баримтлалд ач холбогдол өгөх боллоо. Үүний тодорхой баримт бол 1996 онд УИХ-аас "Монгол улсын төрөөс баримтлах хүн амын бодлого"-ыг батлан гаргаж, түүнийгээ хэрэгжүүлсээр ирсэн явдал юм. Гэвч өнгөрсөн хугацаанд Засгийн эрхэнд гарсан улс төрийн шинэ хүчний бодлого нь барууны өнгө аястай, эдийн засгийн агууламж нь давамгайлж байсны улмаас эдийн засаг, нийгмийн баримжаа алдарч, нийгмийн асуудлууд зохистой шийдлээ хүлээн хоцрох болсон. Ийм байдал үнэхээр газар авснаас манай улсад хүний хүчин зүйлийг гэхээсээ, улс төр, албан тушаал, эд хөрөнгийг урьдал болгодог "бичигдээгүй хууль" үйлчлэх болов. Үнэн чанартаа монгол хүний хөдөлмөр дээр, дооргүй хямарч, дотооддоо бол гадны төсөл юмуу авилгалаар хождог, гадаадад бол "хараар" ч хамаагүй ажил эрхэлдэг болж, хүний нөөцийн менежмент "тэглэсэн". Хүн ам зүйн төрийн бодлого ч суларч, дампуурсан билээ. Ийм тохиолдолд хүн ам зүйн хөгжлийг хүн төвтэй бодлого, хөтөлбөр, үзэл баримтлалын үндсэн дээр байранд нь тавина, гольдролд нь оруулна гэдэг үл гүйцэлдэх шинжтэй. Иймээс хүн ам зүйн хөгжлийн ерөнхий удирдлагыг саяын өгүүлсэн хоёр хувилбар, сонголт, хандлагын хөрсөн дээр төвхнүүлнэ гэдэг эргэлзээтэй бөгөөд эрсдэлтэй. Ерөөсөө хүн ам зүйн хөгжлийн ерөнхий удирдлагаас тухайлсан, төрөлжсөн, нэрлэсэн зориулагдсан бодлого илүү гоочтой, дажгүй өгөөжтэй байж мэднэ. Нийгмээс хүн амын нөхөн үйлдвэрлэл, хэв маяг руу бус, харин хүн ам зүйн бодлогодоо дөрөөлөн нийгмийн хөгжилдөө эргүүлээд нөлөөлж болох

талтай. Учир нь гэвэл хүн ам зүйн үйл явц нь хүн ам зүйн бус бусад үйл явцад ч, нийгмийн хөгжилд ч бүхэлд нь нөлөөлдгөөрөө онцлог билээ.

Эдийн засаг, улс төр, оюун санаа, нийгмийн хүрээнүүд ч бодит ба дэд бүтцийн секторууд ч эдийн засаг, нийгмийн салбарууд ч харьцангуй биеэ даасан, зааг ялгаа нь тодорхой гэмээр байдаг бол хүн ам зүйн үйл явц нь тэр бүхэнд нэвчсэн, шингэсэн байдаг. Энэ утгаараа хүн ам зүйн бодлого нь бүхэлдээ, түүний удирдлага тусгайдаа нийгмийн амьдралын бүхий л салаа мөчирт орцтой, бас гарцтай байдаг.

Орчин үед хүн ам зүйн төгөлдөржилт гэсэн шинэ хандлага, үзэл баримтлал бүрэлдэж, судлаачдаар зогсохгүй улс төрчдийн анхаарлыг соронзон мэт татах болов. Энэ нь прагматик шинжтэйгээрээ, практик агууламж өгөөжөөрөө, том жижиг улсад нийц, таарцтайгаараа өвөрмөц бөгөөд шинэлэг юм. Жишээлэхэд, манай улсад төрөлт буурсаар байгаа ч нийгмийн зарим бүлгийн хувьд бас л өндөр байна гэж үздэг судлаачид бий. Өөрөөр хэлбэл илүүдэл төрөлт байна гэж тайлбарладаг. Нэн ялангуяа ядуу юмуу олон хүүхэдтэй айл, нөхөргүй эмэгтэйчүүдийн хувьд илүүдэл төрөлт газар сайгүй байна, бас генетикийн осолтой "голомтуудад" юмуу архинд донтсон айлд, тахир дутуу хүмүүсийн гэрт хүүхэд төрсөөр байна. Иймэрхүү "бохир", "согогтой" төрөлт нь тарчигхан эдийн засагт, эрүүл мэндийн салбарт, эцэг, эхчүүдэд аз жаргалыг бус, дарамт, зовлон авчирч байна. Тэднийг хүний тооноос биш юмаа гэхэд хүн амын нөхөн үйлдвэрлэлээс хасахыг санал болгох тохиолдол ч гардаг. Хүний эрхийг энд сөхдөг ч тал бий, бас нүднээс далд болгохыг зөвлөдөг ч бий. Хуулиа батлах уу? Эсхүл ёс дэгээ бодох уу? гэсэн ацан шалаанд орчихдог. Энд ямар гарц байх вэ? Ямар шийдэлд хүрэх вэ? Асуулт зөндөө, хариулт олдохгүй зовоодог. Үнэндээ амьдрал баян, хууль цааз явцуу, давчуу, дээр нь шударга биш гээд бөөн маргаан дэгдэнэ. Тэгэхлээр хувь хүний заяа төөргөөр хөөцөлдөх бус, төрийн бодлогыг дагаж, төрийн хуулийг сахих учиртай.

Монголын хүн ам зүйн хөгжлийн удирдлагын тогтолцоонд **нийгмийн ба төрийн** удирдлага, тэдгээрийн харьцаа, шүтэлцээ чухал ач холбогдолтой. Нийгмийн удирдлагын хувьд хэлэхэд манай улсад янз бүрийн үзэл бодол бүхий улс төрийн хүчнүүд байгаа бөгөөд тэдний засгийн эрх барих магадлал "давалгаат" хийгээд "солбицолт" шинжтэй байна. Улс төрийн аль нам, эвсэл засгийн эрхэнд гарснаас нийгмийн бодлогын өнгө аяс бүхэлдээ, хүн ам зүйн бодлогынх жичдээ өөрчлөгдөнө. Гэхдээ манай улсын хүн амын бүтэц, бүрэлдэхүүн нь нийгмийн болоод хүн ам зүйн бодлогодоо эрс өөрчлөлт хийх бололцоо, боломжийг улс төрийн аль ч хүчинд олгохгүй. Энэ нь зэрэг, сөрөг талуудтай. Сөрөг тал нь гэвэл хүн ам зүйн алдаатай юмуу урагш муутай бодлого, арга хэмжээ үе дамжин өвлөгдөх магадлалтай. Тийм байдал өдгөө хүн ам зүйн бодлого биш гэхэд боловсролын салбарт илт ажиглагдаж байна. Эндээс нийгмийн бодлого үлэмжхэн адармаатай,

хэрэгжүүлсэн арга хэмжээ нь буруу хазгай болдгийг л хэлэх гэсэн юм. Ганцхан жишээ татахад, Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтээс үзэхэд олон сайхан жишээ, бахархмаар үр дүн бишгүй бий. Гэхдээ л ядуурал буураагүй, харин ч гүнзгийрэл хэмээх өөр нэгэн үзүүлэлтээр хэмжигдэх болов. Яагаад гэвэл ядуучуудын хувьд үнэ төлбөргүй, буяны тусламжид амтшин ядуу хэвээрээ аж төрөх, боломжийн нэгнийх нь хувьд зээл авах, татвараас зайлсхийхийн тулд ядуурал ашигтай, бас хаялагатай байна.

ЯБҮХ-ийн хүрээнд манай улсын хөгжлийг дэмжигч, хандивлагч улсуудаас амласан зээл, тусламжийн хөрөнгийн тэн хагасыг л авсан, түүний хичнээн хувь нь "эзэндээ" очсон нь бүдэг бадаг, төлөгдөөгүй зээл өссөөр ирсэн нь маргашгүй үнэн.

Хүн ам зүйн хөгжлийн удирдлагын өөр нэгэн чиглэл нь удирдлагын зохицол, шатлалын хослолоор илэрхийлэгдэнэ. Гэтэл манай улсад бүрэлдэн тогтоод байгаа төрийн захиргааны удирдлагын бүтцэд шатлалын тал хөгжсэн мөртлөө зохицуулалтын тал нь сул байна. Хүн ам зүйн хувьд гэхэд социализмын үеийн төлөвлөлт Сайхгүй болов. Хүн амын прогнозчлол тасалдлын байдалд, "дуслын тариатай" төстэй байна. Засгийн газрын тэнхмийн яамдууд цөөрсөн ч "баг – сум /хороо/ -аймаг /дүүрэг/ -Засгийн газрын хэрэгжүүлэгч ба тохируулагч агентлаг –яам –засгийн газар" гэсэн олон шатат, олон албан тушаал дамжсан хүнд суртлын тогтолцоо хэвээрээ шахам байна. Орон тоог цомхотгож, албан газар, хэлтсүүдийг татан буулгасан ч Засгийн газрын огцролт, бүтцийн өөрчлөлт, зохион байгуулалтын арга хэмжээний далбаан дор дахин сэргэж, хүнд суртлаас ардчилал руу бус, харин дахин зохион байгуулагдсан, дахин сэргэсэн хүнд суртал руу хэлбийх нь илүүтэй байна.

Нийгмийн удирдлагын тогтолцоон дахь шатлал өгсөх, өндөржих, олон дамжлагатай болж, харин зохицуулалт, зөвшил нь хомсдолд орж, нэг бол албан тушаалтан дураараа дургих, эсхүл удирдлагын аль нэгэн шатанд эзэнгүйдэх, хийдэгдэх байдалд хүрч байна. Сүүлийн үед хүн ам зүйн хөгжлийн удирдлага шат дамжлага, зэрэг дэвийнхээ хувьд нэлээд өөрчлөгдсөн ч зөвшил, зохицуулалтынхаа талаас хуучнаараа байна. Мэдээллийн урсгал дороосоо дээшээ байна. Харин хажуу тийшээгээ буюу сум-сум, аймаг-аймаг, Яам-Яам-Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагийн хооронд ажил хэргийн түвшинд хүрээгүй байна. Иймэрхүү байдал нь мэдээллийн хомсдол, гачаалыг бий болгоод зогсохгүй удирдлагын, тэр тусмаа мэдээллийнхээ агуулга, цар хэмжээгээр тодорхойлогддог хүн ам зүйн хөгжлийн удирдлагыг гацаанд оруулж, эрэмдэг зэрэмдэг болгож байна. Мэдээллийн "босоо" чиглэлийн урсгал захиргаадалтын үед төдийгүй шинэчлэлийн өнөөгийн нөхцөлд ноёрхсоны харгайгаар доод шатанд хуурамч, хагас дутуу мэдээлэл цуглуулах, дунд

шатанд өнгөц боловсруулалт хийх, удирдлагын сонирхолд нийцүүлэн шүүх, засвар оруулах, үнэнийг гуйвуулах, дээд шатанд мэдээллийг өмчлөх, нууцлах, дарагдуулснаас мэдээллийн хуурамч цангалт, өлсгөлөн үүсэх, үзлэг шалгалтыг шохоорхох, компанит ажилд шимтэх явдал байсаар байна.

Өнөөгийн хүн ам зүйн ч, хүний нөөцийн ч менежмент нь шинжлэх ухааны түвшинд битгий хэл, сурах бичгийн түвшинд ч хүрээгүй байна. Орчин үеийн менежментийн шинжлэх ухааны утга агуулгаар хүн ам зүйн менежмент нь "түүхийгээрээ" ч, хүний нөөцийн менежмент гараанаасаа хөдөлж, сурах бичгийн түвшинд цэгцрэх хандлагатай боллоо.

Нэг талаар хүн ам зүйн ба хүний нөөцийн менежментийг хослуулах, нөгөө талаар хүн ам зүйн удирдлагыг боловсронгуй болгох арга замыг тодруулах үүднээс эх орныхоо хүн ам зүйн хөгжлийн удирдлагатай шууд холбогдох тодорхой асуудлын талаар өөрийн санал бодлоо илэрхийлье. Тухайлбал:

1. Хүн ам зүйн хөгжлийн удирдлагын салаа мөчир нь технологийн удирдлага билээ. Гэтэл манайд хүн ам зүйн технологийн удирдлагыг үл тоох, цалгардуулах, байгалийн жам ёсонд даатгах явдал нийтлэг байна. Үүнээс болоод хүн ам зүйн хөгжлийн технологийн аль нэг дамжлагад ачаалал, аль нэг цэгт нь "богино холбоо" үүсдэг байна. Тиймэрхүү жишээний нэг нь үр хөндөлт мөн билээ.

Орчин үеийн анагаах ухаан нөхөн үржихүйн технологид дараах дөрвөн чиглэлээр нөлөөлж байна. Үүнд:

а/. Жирэмслэлтээс сэргийлэхүй. Урьд нь хүсээгүй жирэмслэлт, үр хүүхдээс зайлсхийх, хяналт тавих боломж маш хязгаарлагдмал байсан бол жирэмслэлтээс сэргийлэх эм, тариа, ерөндөг, бэлгэвч мэт бий болж, улам бүр боловсронгуй агаад хүртээмжтэй болж ирлээ.

б/. Жирэмсэн үеийн эх барихүйн үйлчилгээ. Сүүлийн үед үр хөврөлийг эхний шатанд мэддэг, хянадаг болоод зогсохгүй хэвлийд нь эмчилж байна. Үүний ачаар хүүхэд олох, хүүхэд тогтоох зовлонгоос олон эхчүүд ангижирлаа.

в/. Мэргэжлийн эх барихүй. Сүүлийн дөчөөд жилд эхчүүд гэртээ төрөхөө больж, эмнэлэгт амарждаг болсноор эх, нялхсын эндэгдэл эрс буурлаа.

г/. Урагт нөлөөлөхүй. Үргүйдлийг даван туулж, бэлгийн харилцааны замаар бус үр хөврөл шилжүүлэх, өсгөх технологи бий болов. 1930-аад оны үед зохиомлоор үр тогтоож байсан бол дахиад гучин жилийн дараа үргүйдлийг арилгах эмийг нээв. Сонирхолтой нь энэ эмийг уухад ихэр хүүхэд төрүүлэх магадлал ихэсдэг аж. Хүүхэд үрчлэх явдал хумигдаж, харин ураг тээгч эхчүүд бий болов. Энэ нь ёс зүйн болон эрхийн олон асуудлыг үүсгэж, эх, үрийн эрхийг хөндсөн маргаан олширч, зарим нэг улс оронд тээгч эхийн эрхийг хязгаарлажээ. Манай улс 1975 онд гэр бүлийн

биеэ даасан хуультай болсон ба хорин таван жил түүнийгээ шинэчилж чадаагүй явсаар өнгөрсөн жил шинэ хуультай боллоо. Тэрхүү хууль айл гэрийн амьдралд шинээр бий болсон хамтын өмчөөс хувь хүртэх, өвлөх, гадаадынхантай гэрлэх, гадаадын хүнд хүүхэд үрчлүүлэх гэх мэтийг зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлснээрээ шинэлэг бөгөөд урагшаа ахисан боловч харин ирээдүйг бодолцооноороо дутмаг болжээ.

2. Манай улсын хүн ам зүйн хөгжлийн удирдлагад хүйсийн онцлогийг харгалзан удирдах хэрэгцээ, шаардлага бий боллоо. Хэдийгээр социализмын үед хүний эрхийн асуудалд тунхаглалын шинжтэй ханддаг байсан ч манай орон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах талаар чамлахааргүй амжилтад хүрсэн. Эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалалтыг өргөжүүлж, нийгмийн алагчлал, гадуурхлыг арилгасны үр дүнд монгол эмэгтэйчүүдийн нийгмийн байдал, ажил эрхлэлт, боловсрол, мэргэжил эзэмшилтэд дориун ахиц гарсан юм. Түүгээр ч зогсохгүй улс ардын аж ахуйн зарим салбарт эмэгтэйчүүдийн оролцоо хэтрүү үр дүнд хүрч, эрэгтэйчүүдийг түрж, шахсаны улмаас хүйсийн асуудал анхаарал татах боллоо. Түүрүүчийн тогтолцооны үеийн Марксист эмэгтэйчүүдийн хөдөлгөөн ардчиллын жилүүдэд радикал, либерал эмэгтэйчүүдийн хөдөлгөөнөөр солигдлоо.

Захиргаадлын жилүүдийн сүүлчээс авахуулаад дээд, тусгай дунд боловсрол эзэмшигчдийн дунд эмэгтэйчүүдийн хувийн жин зонхилж, улмаар дээд шатны боловсролын түвшингээр эрэгтэйчүүдийг "гүйцэж түрүүлсэн" нь сайхан амжилт боловч мэргэжилтэй боловсон хүчний чанар чансаа, албан тушаал дэвшилт, нарийн мэргэшилт, тогтвор суурьшил зэрэгт зарим бэрхшээлтэй асуудлыг бий болгосон. Ийм учраас хүн ам зүйн хөгжлийг хүйсээр дамжуулан удирдах явдал тулгамдсан зорилт болж байна.

3. Хүн ам зүйн хөгжлийн удирдлагын тогтолцоонд хүн амын зонхилох бүлгүүдийн удирдлага хүндтэй байр суурь эзэлсээр ирсэн, эзлэх ч болно. Сүүлийн жилүүдэд нэг талаас ардчилал хөгжиж, нөгөө талаас иргэний нийгэм төлөвшин буйн үр дүнд нэг намыг дагасан олон нийтийн байгууллагууд шинэчлэн зохион байгуулагдсаны дээр төрийн бус байгууллага олноор байгуулагдав. Гэтэл хүн ам зүйн үзүүлэлтүүд тухайлбал, нас, хүйс, арьсны өнгө, угсаа сурвалжийн шинжүүд өөрчлөгддөггүй, гагцхүү нас дэвшихийн эрхээр нэг нь нөгөөдөө шилждэг жам ёсны байдал нь хүүхэд, идэрчүүд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадын байгууллагууд олноор үүсэх, хоорондоо шударгаар өрсөлдөх, олон ургальч үзлийг уралдуулах боломж олгож байна.

Одоо нийгмийн болон хүн ам зүйн үүднээс гойд анхаарал татаж буй зүйлсийн талаар товчхон өгүүлье. Нэгдүгээрт, манай хүн амын доторх

хамгийн өнөр, жин дардаг бүлэг нь хүүхдүүд билээ. Тэдний өсөн торних орчин, нийгэмших үйл явцад ихээхэн өөрчлөлт гарсны улмаас хүүхэд, өсвөр үеийнхэн нэг талаас нийгмийн хувьд нялхарч хэнээрч байна, нөгөө талаас зарим нэг нь хэтэрхий хэрсүүжин догширч, насанд хүрэгчид, эцэг эхчүүдийн хараа хяналтаас мултарч байна. Товчилж хэлбэл, хүүхдийн төлөө бодлогыг хүүхдийн өөрсдийнх нь бодлогоор сольж, удирдлагын шинэчлэл хийхийг санал болгож байна.

Чухамхүү ийм бодлого дутагдсанаас хүүхдийн, залгамж үеийн төрийн бодлого суларч, тэнэмэл хүүхдийнхээр солигдлоо гэхэд нэг их хэтрүүлэг болохгүй буй заа. Хоёрдугаарт, хотжилтын нөлөөгөөр өнөөгийн өсвөр үеийнхний бие бялдарын бойжилт түргэсэж, нийгмийнх нь аажууссанаас хүүхэд, залуучуудын зааг дахь идэрчүүдийн асуудал хойшлуулшгүй шинжтэй боллоо. Тэдний гол онцлог бол тухайн нийгмийнхээ заяасан төрөлх статусаа өөрчилж, нийгмийн шинэ статустай болдог оршино. Гэтэл нийгмийн энэхүү захиалгыг боловсролын шинэчлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн өөрчлөлт, чөлөөт хэвлэлийн төлөвшил, нийгмийн хүрээний бусад салбаруудын төвхнөл хангаж чадахгүй байна. Хүүхдүүдээсээ нуух, хүүхдүүдийнхээ дэргэд ичихээ больсон орчин үеийн нийгэмд хүүхэд нас алга боллоо гэсэн үзэл бодол байдаг. Үүнийг сайнаар бус, саараар нь нотлох мэт идэрчүүдийн үйлдсэн гэмт хэргийн давтамж, нэр төрөл, зохион байгуулалт, арга хэрэгсэл насанд хүрэгчдийнхтэй гайхмаар адилсаж, фото-зураг мэт хуулбарлагдах болсон нь сэтгэл эмзэглүүлж байна. Гуравдугаарт, Манай улсын хүн амын залуужилт хоёр дахь мөчлөгөөрөө ирэх зуунд үргэлжлэхийг хүн амын прогнозын бүхий л хувилбарууд харуулж байна. Цаашдаа нийт хүн амын бүрэлдэхүүнд залуучуудын эзлэх хувийн жин буурна, харин залуучуудынх одоогийн хүүхдүүд идэр болон залуу насанд дэвших хүртэл үргэлжилнэ. Өөрөөр хэлбэл залуучуудын өсөлт хүн амын бусад бүлгийнхээс дээгүүр байна.

Хүн амын залуужилт нь мөчлөгийн эхний үед сургуулийн өмнөх ба сургуулийн насны байгууллага, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарт хүндрэл учруулж байсан бол одоо үед ажлын байрны хүрэлцээ, их, дээд сургуулийн элсэлт, төгсөлт, хүн амын шилжих хөдөлгөөн, нийгмийн шилжилт зэрэгт гойд нөлөөлж, материалын болон оюуны хөрөнгө оруулалт, үйлчилгээг ихээр шаардана. Гэтэл манай улсад хямрал ужгирч, хямрал эхэлсэн ерээд оныхоо түвшинд хүрэхгүй байна. Ажиллах хүчний, хөдөлмөрийн нөөцийн эх сурвалж болсон залуучууд маань "илүүдэл хүмүүс" болон хувирах аюул нүүрлэж байна. Иймд залуучуудын талаар хүчтэй бөгөөд үр ашигтай бодлого, удирдлагыг яаралтай зүгшрүүлэх шаардлагатай. Сүүлийн үед залуучуудын хөдөлгөөн улс төрийн хүчнүүдийг даган задарч, залуучуудын асуудал эрхлэх учиртай төр засгийн төв байгууллагууд "буланд шахагдаж", яамны бөөрөнд наалджээ. Тэгтэл залуучуудын олон асуудал тунарч, тэднийг хөдөлгөгч бус,

бусниулагч хүч болон хувирч магадгүй. Орон гэргүй, ажилгүй, ядуу хүмүүсийн, гэмт хэрэгтний дийлэнх нь залуучууд байна. Тэднийг нийгмийн бүлгийнх нь тооны ихээр тайлбарлах нь үнэмшилтэй ч ажил үйлийн зохистой шийдэл огтхон ч биш ээ. Дөрөвдүгээрт, Манай улсын хүн амын тэн хагастай тэнцдэг охид, эмэгтэйчүүдийн байдал, тийм ч базаалтай биш байна. Айл гэрийн ажлын хүндийг үүрдэг мөртлөө хөдөлмөрийн зах зээл дээр гадуурхагдаж, гэр орондоо чимээгүй дарамт, хүчирхийлэлд өртөж байна. Эмэгтэйчүүд гэмт хэрэг үйлдэж, эртний мэргэжлээ сэргээж биеэ үнэлж байна. Гэхдээ үүгээр далимдуулж эмэгтэйчүүдийн бүтээсэн хийгээд бүтээж байгаа үйлс, идэвхи зүтгэл, оролцоог харлуулж болохгүй. Монголын эмэгтэйчүүд давуу талаа, ур чадвараа, боловсролын түвшнээ, хэлний мэдлэгээ бизнесийн хүрээнд ч, төрийн албанд ч харуулж байна. Гэхдээ шийдвэр гаргах түвшинд хүрэлцэхүйц төлөөлөлгүй хэвээрээ. Эмэгтэйчүүдийн асуудлын заримыг нь хүйстэй холбогдуулж түрүүхэн, заримыг нь одоохон ярих тул орхизноё. Тавдугаарт, Манай улсын хүн амын бүрэлдэхүүн, бүтэц залуужмал ч өндөр настны асуудал огт байхгүй гэсэн үг биш. Ялангуяа Улсын Бага Хурлаас ажилгүйдлийг бууруулах нэрийдлээр ажилласан жилийг тооцон, хөдөлмөрийн насны олон мянган хүнийг тэтгэвэрт суулгаснаас тэдний ч, өндөр настны ч асуудал айхтар хүндэрсэн. Гагцхүү ахмадын жилийн ажлын хүрээнд нэгэн эмзэг асуудал болох 1990 оноос өмнө, хойно тэтгэвэр тогтоолгогчдын тэтгэврийн зөрүүг арилгалаа. Энэ бол том шийдэл. Гэвч өндөр настны нийгмийн халамж, хамгаалал үүгээр шувтрахгүй. Тэр бүү хэл дэлхийн хүн амын амин чухал асуудал болоод байгаа хөгшрөлт манай орныг тойрохгүй, дайрна. Үүнд одооноос бэлтгэлтэй байх шаардлагатай.

4. Хүн ам зүйн удирдлагын маш чухал чиглэл бол гэрлэлт-айл гэрийн дотнох, гаднах асуудлуудын шийдэл болно. Дал, наяд оны имрүүн төрөлтийн үеийн залуус одоо гэрлэж, өрх тусгаарлаж байна. Гэтэл орон сууцны барилга барилт, шинэ гэр төхөөрөлт бараг зогссон, харин саяхнаас хотод хөрөнгө оруулалтын сэргэлт ажиглагдаж байна. Модны экспортод тавьсан хязгаарлалт ч нааштайгаар нөлөөлөх янзтай. Гэлээ ч гэсэн хорогдох орон гэрийн асуудал маш хурц, мөддөө шийдэгдэхгүй шинжтэй.

Гэрлэлт- айл гэрийн амин чухал асуудал орон гэр хараахан биш ээ. Хүн төрөлхтөн үр удмаа дамжуулах ганцхан арга олсон. Тэр нь гэр бүл. Манайд ч, бусдад ч ялгаагүй адилхан. Яагаад тийм байдаг вэ? гэхээр айл гэрийн хос багана нь гэрлэгч хосын хайр дурлал, ёс суртахуун; эхийн, эцгийн үр хүүхдээ гэсэн өгөөмөр сэтгэл байдаг. Гэтэл манай улсын статистикийн эмхтгэлийг сөхөнгүүт эмэгтэй тэргүүлэгчтэй өрх гэсэн хүснэгтийн нэр нүднээ дурайна. 1998 оны байдлаар 54.5 мянган ийм өрх байгаа нь нийт өрхийн аравны нэгтэй тэнцэж байна. Үүнийг харахнаа сэтгэл онгоймоор ч юм шиг. 1989-1998 оны хооронд нийт өрх 25-хан хувиар өссөн байхад эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 3.3 дахин өсчээ. Ий... өрхийн тоо энэхүү

хурдцаараа нэмэгдвэл элэг бүтэн өрхийг гүйцэж ч магадгүй. Иймэрхүү бүртгэл хөтлөхгүй, статистикийн эмхтгэл гаргахгүйн тулд айл гэрийн бодлогодоо өөрчлөлт оруулах шаардлагатай. Үнэн чанартаа сүүлийн үеийн гэр бүлийн талаарх бодлого биш юмаа гэхэд бүртгэл нь айл гэрийг бэхжүүлэхэд бус салж сарниулахад чиглэгдсэн. Түүнийг элдэв төсөл, хөтөлбөрүүд өнгөлөн далдалж, хөхүүлэн урамшуулж буйд нэг их ухаан зарахгүй.

5. Хүн ам зүйн хөгжлийн удирдлагын өөр нэг гол чиглэл бол хүн амын хэтийн тооцоо байдаг. Манай улсын хүн амын хэтийн тооцоог эрдэмтэн Р. Гүр болон үндэсний судлаачид төдийгүй Ricardo F. Neupert зэрэг гадаадын судлаач эрдэмтэн олон янзын хувилбараар хийсэн байдаг. Гэвч эдгээр тооцооллын хувилбаруудын үндсэн суурь материал нь хэт хуучирсан, өөрөөр хэлбэл монголын хүн амын 1979, 1989 оны тооллогын материал дээр тулгуурлаж, төрөлт өндөр байх үеийн нийгмийн тогтолцоо, сэтгэлгээгээр хандаж боловсруулагдсан тул тэдгээрийг бодит байдалд ойртуулах үүднээс нэлээд засварлаж шаардлагатай болсон. Манай оронд сүүлийн жилүүдэд тохиосон төрөл ийн огцом уналт, шилжилтийн үеийн хүн амын өсөлтийн ерөнхий хандлага, төрийн бодлогын чиглэл зэргийг харгалзан тооцоход 2020 онд монгол улсын хүн ам 3.5, 2025 онд 4.0 саяд тус тус хүрэх магадлалтай байна.

XXI зууны монголчууд нээлттэй нийгэмд аж төрнө. Манайхан гадагшаа гарна, гадаадынхан манайд нүүж ирнэ, зочилж ирнэ, түр хугацаагаар ирнэ. Үүнд "Гадаадын харъяат ба харъяалалгүй иргэдийн эрх зүйн байдлын тухай" Монгол улсын хууль, түүний гурван хувийн босго өндөрлөх, намдахыг өнөөдөр хэлэхэд хэцүү. Хятадын эдийн засгийн шилжилтийн гайхамшгийн нэгийг түүний хоцрогдлоор тайлбарлах явдал байдаг. Энэ бол огт оргүй зүйл биш ээ. Түүний нэгэн адил манай орны буурай хөгжил нь гадаадынхны ирэх, шилжих хөдөлгөөнийг барьж байгаа үндсэн шалтгаан ч байж магадгүй. Цаашдаа, ялангуяа ирэх зуунд Монгол орон хямралынхаа намагт суухгүй, дандаа зээл, тусламжаар амьдрах аргагүй, харин ирмүүхэн хотжих боломжтой. Түүнийгээ хэрэгжүүлж чадвал ард түмний амьжиргааны түвшин дээшилнэ. Тэр үед манай улсад гадаадынхан одоогийнх шиг, онгоц, галт тэрэгний цөөхөн хуваарь төдийхнөөр бус, харин өөр зам харгуйгаар, тээврийн янз бүрийн хэрэгслээр "цутган" орж ирэхийг үгүйсгэх аргагүй. Тийм тохиолдолд генетикийн "хохилдолт", соёлын "сэлбэлт" болно. Тэгэхлээр цагаачид, магадгүй дүрвэгчид орж ирэхлээр бажигдан сандрах бус, харин улс үндэстнийхээ эрх ашиг, аюулгүй байдлыг хангасан ухаалаг, уян хатан, өгөөжтэй хүн ам зүйн бодлогоо сэргүүлэн тавих нь өлзийтэй бөгөөд ирээдүйтэй байх болно.

Шинэ зууны Монгол улс дэлхий дахины нийтлэг жишгээс гажих бус, харин даяарчлалын, бас бус нутгийн хөгжлийн хүрээнд татагдан орно, гэхдээ

уусан шингэхгүй, өөрийн язгуур шинж, өвөрмөц онцлогоо хадгалан хөгжинө. Энэ бол манай нийт нийгмийн хөгжлийн ч, хүн ам зүйн хөгжлийн ч диалектик мөн.